



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/365

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар  
тахлаас урьдчилан сэргийлэх, нэг удаагийн  
хамгаалах хэрэгслийн нормыг шинэчлэн  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3. дахь хэсэг, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2. дахь заалт, Шадар сайдын 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 26 дугаар тушаалаар батлагдсан "Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний стратеги"-ийн 3.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021 стандартын 3.7, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалын Коронавируст халдвар (Ковид-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр зааврын 3.7.5 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төв болон түүний харьяа салбар, нэгжийн ажилтнуудыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор хуваарьт өдөр ажиллах ажилтнуудад олгох нэг удаагийн хамгаалах хэрэгслийн нормыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллах, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг тогтоосон үед дээрх нормын хангалтыг нэг сараас доошгүй хугацаагаар тооцон нөөц бүрдүүлэхийг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтэс (С.Батхуяг)-т, Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах штаб (П.Гантөгс)-т тус тус үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх  
бэлэн байдлыг хангах зорилгоор хуваарьт өдөр ажиллах ажилтнуудад  
олгох нэг удаагийн хамгаалах хэрэгслийн норм

№	Харьяа, салбар нэгжийн нэр	Ажлын горим	Маск	Бээлий /хос/	Нүүр-ний хаалт	Малгай	Халад	Иж бүрэн хамгаалалтын хувцас
1.	Үйлдвэрлэлийн ХАБЭА хариуцсан ажилтан	Өдрөөр	2	1	1	1	1	-
2.	Шинжилгээ авах баг	Тухай бүр	-	-	-	-	-	1
3.	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
4.	Холбоо, навигаци, ажиглалтын алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
5.	Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
6.	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
7.	"Буянт-Ухаа" нисэх буудлын ашиглалтын алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
		Өдрөөр	2	2	-	1	-	-
8.	Аюулгүй байдал, хамгаалалтын алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
9.	Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
10.	Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
		Өдрөөр	2	2	-	1	-	-
11.	Эрүүл мэнд, спортын цогцолбор	Өдрөөр	2	2	-	1	-	-
12.	Шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн алба	Ээлжээр	4	2	-	1	-	-
		Өдрөөр	2	2	-	1	-	-
13.	Орон нутгийн нисэх	Ээлжээр	2	-	-	-	-	-